БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 03 ДУГААР УЛИРАЛД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2022.09.23

9 иргэн, 10 ААН байгууллагын төслийн баримт бичигт БОНБЕҮ-ний дүгнэлт, “Монголын Алт” ХХКомпани болон “Агайын” ХХК-ны Толбо сумд үйл ажиллагаа явуулдаг уурын зууханд 2022онд ус ашиглуулах дүгнэлт гаргаж тус тус хүргүүлэв.

Тус аймгийн хэмжээнд “Нүхэн жорлон, угаагдсаны нүхний техникийн шаардлага” MNS5924:2015 стандарт, болон цэвэрлэгээний ажлыг зохион байгуулсан ажлын биелэлтийг хавсралтаар гаргаж БОАЖЯ-д, Байгууллагын Төрийн жинхэнэ албан хаагч, Төрийн үйлчилгээний албан хаагч нарын 2022оны судалгааг аймгийн ТАЗСЗ-д, Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангаж ажиллах, аялагчдын тав тухтай орчинд амарч зугаалах нөхцөлийг бүрдүүлэх, эко жорлон барьж байнга ажиллуулах талаар хүсэлтийг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 12 жуулчны баазуудад хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооноос зохион байгуулж буй “ЯНДАНГАА ХӨӨЛЬЕ, ӨНТЭЙ ӨВӨЛЖЬЕ” аяныг тус аймгийн хэмжээнд зохион байгуулах тухай Аймгийн Засаг даргын 2022 оны 09-р сарын 14-ний өдрийн А/684 дугаар захирамжийн дагуу ажлын хэсэг байгуулан төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

БОАЖСайдын 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 06 дугаар албан даалгаврын дагуу аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа ШТС, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын хөрсний бохирдол үүсгэгч нүхэн жорлонгийн хэрэглээг зогсоож, стандартын шаардлагад нийцсэн нийтийн ариун цэврийн байгууламж байгуулах талаар үүрэг чиглэл өгч, хамтран ажиллаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, тус аймгийн Засаг даргын хооронд байгуулсан 2022онд хамтран ажиллах гэрээний дагуу Баяннуур, Ногооннуур, Толбо, Цэнгэл сумын байгаль хамгаалагчдад 4 шинэ мотоцикл гардуулж өглөө.

Усан сан бүхий газрыг бохирдож, хомсдохоос хамгаалах арга хэмжээ авах тухай Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2022 оны 08 дугаар сарын 31-ний

өдрийн 09 дүгээр албан даалгаврыг аймгийн хэмжээнд зохион байгуулан 44га газрыг цэвэрлэж, нийт 23,1тонн хогийг нэгдсэн хогийн цэгт хүргүүлэн ажиллаа.

СУРТАЛЧИЛГААНЫ ТАЛААР:

Хог хаягдлын тухай, Зөрчлийн тухай хууль болон Аялал жуулчлал, Хог хаягдлын талаар хэрэгжүүлж буй ажлын талаар орон нутгийн хэвэл мэдээллээр сурталчилгааны ажлыг зохион байгууллаа.

БОАЖЯамнаас зохион байгуулж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл”-ийн II/III шатны хүрээнд БОАЖГазар, МАНУТХГНХЗахиргаа, Хөх сэрхийн нурууны ДЦГазрын мэргэжилтэн, байгаль хамгаалагчдад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль эрх зүйн мэдлэг олгож, байгаль хамгаалагчдын ажлын орчны, сөрөг хүчин зүйлсийг бууруулах, эрсдэл ослоос сэргийлэх аюулгүй эрсдэлгүй ажлаа гүйцэтгэх чадварт сургаж, яаралтай үед өөрийгөө болон бусдыг авран хамгаалах арга барилд сургах зорилгоор “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн” сургалт болон эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг 2022оны 07-р сарын 20,21-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Тус арга хэмжээнд манай БОАЖГазрын 15 байгаль хамгаалагч, 7 мэргэжилтнийг оролцуулав.

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт орсон бүх албан хаагчдыг Лаборатори, Багажийн бүх шинжилгээнд хамруулан Мэдрэл, Үе мөч, Зүрх судас, Дотоод шүүрэл, Дүрс оношилгоо, Дотрын нарийн мэргэжлийн эмч нар оношилгоо хийж, зөвлөгөө өгч ажиллаа.

"Таван Богд" ХХК, "ХХХ хөгжлийн төв" хамтран Улаанбаатар хотод зохион байгуулсан Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтад газрын дарга болон холбогдох албан хаагч нар, Говьсүмбэр аймгийн Чойр хотод 08-р сарын 08,09-ний өдрүүдэд зохион байгуулсан “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний зорилтыг бүс, орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлтийг сайжруулах нь” сургалт зөвлөгөөнд холбогдох мэргэжилтнүүд, АТГ-аас ХАСХОМэдүүлэг гаргах программын шинэчилсэнтэй холбогдуулан зохион байгуулсан нэг өдрийн цахим сургалтад ахлах мэргэжилтэн тус тус оролцов.

АН АМЬТНЫ ТАЛААР:

Аймгийн хэмжээний агнуурын бүс нутгуудад тусгай зориулалтаар агнах барих ховор ан амьтанд хяналт тавих ажлыг зохион байгууллаа. Энэ жил нийт 46 ховор ан агнагдах байсан ба одоогийн байдлаар 37 агнагдсан болно.




МОНГОЛ УЛС
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
MINISTRY OF ENVIRONMENT AND TOURISM
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2016 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн
А/27 тоот тушаалын 4 дүгээр хавсралт

АН АГНАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
SPECIAL HUNTING PERMIT

Дугаар /Permit number/ 0210267
Аймаг /Province/ БАЯН-ӨЛГИЙ
Сум /Soum/ НОГООН НУУР
Зөвшөөрөгдөгч байгуулга /Outfitters/ ХАНОМАРО ТУР ХХК
Агнуурын бүс нутаг /Hunting area/ ХАВЦАЛ
Агнуур хийх эрхтэн нэр /Name of hunter/ CHARLES BRADLEY PETERS, RONNIE VANCE FANN
Менежментийн эрхлэгч /Management authority/ ХАНОМАРО ТУР ХХК
Улс /Country/ АНУ
Агнах амьтны үзүүлэн нэр, too толгой /Game species, quota/ АЛТАЙН ТЭХ - ХОЁР ТОЛГОЙ
Олгосон он, сар, өдөр /Issued date/ 2022 оны 07 сарын 22 өдөр
Хүчинтэй хугацаа /Hunting period/ 2022.07.24- 2022.08.08
Тамга /Stamp/
Зөвшөөрөл олгосон /Permit issued by/ АУБХХ-ийн ЗӨВЛӨ
Гарын үсэг /Signature/ П.Цогтсайхан
ХБОБНУ-ын мэргэжилтэн /Staff/ Ж.Менхдөш

“Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх 45 хоногийн аян” зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын 2022 оны А/546 захирамжийн дагуу байгууллагын нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллав. Уг аяны хүрээнд сумуудад ажиллаж байгаа байгаль хамгаалагчид хариуцсан газар нутагт холбогдох байгууллагуудтай хамтран эргүүлд гарч, хяналт шалгалтыг эрчимжүүлж, сэрэмжлүүлэх мэдээллийн самбар байршуулан, ард иргэдэд тарваган тахлаас урьдчилан сэргийлэх, хууль таниулах сурталчилгааны материал тарааж, орон нутгийн хэвэл мэдээлэл болон байгууллагын цахим хуудсаар сурталчилгааны ажлыг зохион байгуулан, хийсэн ажлын тайланг аймгийн Зоонозын өвчин судлалын төвд цахимаар хүргүүлэн ажиллав.



БАТЛАВ: БОАЖГАЗРЫН ДАРГА Ш.МАРАТ

ТАРВАГАН ТАХАЛ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ 45 ХОНОГИЙН АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2022.08.08

№	Гүйцэтгэх ажил	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
1	Ард иргэдэд тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх сурталчилгааны ажлыг цахим мэдээллээр болон орон нутгийн радио, телевизээр сурталчлах	8,9 сард	И.Жулдыз Н.Болатхан
2	Хууль бус ан агнууртай холбоотой хяналт шалгалтыг эрчимжүүлэх, худалдааны төвүүдэд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах	8,9 сард	Б.Шөгөн А.Дамысбек Х.Сулушаш
3	Бүх албан хаагч нарыг тарваган тахлын дархлаажуулалтанд хамруулах	8-р сард	С.Мандат Б.Шөгөн И.Жулдыз
4	Харьяалах нутаг дэвсгэрийн эрсдэлтэй тарвага нутагших газарт байнгын эргүүл, хяналт шалгалт хийх	8,9 сард	Б.Шөгөн, Сумдын байгаль хамгаалагчид
5	Аймгийн Засаг даргын 2022оны А/546 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан хуваарийн дагуу хяналт шалгалт хийх	27/VIII-31/VIII	Б.Шөгөн И.Жулдыз А.Дамысбек Х.Сулушаш М.Мөрөкө Д.Мир О.Лена
6	Шаардлагатай үед эргүүл, хяналтын цэгт үүрэг гүйцэтгэх	8,9 сард	Б.Шөгөн И.Жулдыз Б.Хасым М.Марина Н.Болатхан Ш.Айсулу А.Дамысбек Ө.Дауренбек Б.Гүлжан Х.Даут Х.Сулушаш М.Мөрөкө Д.Мир О.Лена

Боловсруулсан: Ахлах мэргэжилтэн С.Мандат



ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР:

Өлгий сумын байгаль хамгаалагчид аймгийн төвийн “Ах дам”, “Тирлик” захууд болон бусад үйлчилгээний газруудад хяналт тавьж, Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад оруулсан Алтайн сонгиныг хууль

бусаар түүж бэлтгэн худалдах, худалдаж авахгүй байх талаар зөвлөмж өгч, холбогдох хуулийн заалтыг танилцуулан ажиллав.

ХОГ ХАЯГДЛЫН ТАЛААР:

БОАЖСайдын 2022 оны 02 дугаар албан даалгаврыг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх, аймгийн Засаг даргын 2022.06.03-ны өдрийн А/377 дугаартай Хоггүй Цэмцгэр Өлгий аян зохион байгуулах захирамж, Хоггүй цэвэр Баян-Өлгий дээд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Өлгий сумын 1,2,3,4,5,6,8,9,10,12,13-р багуудын нутаг дэвсгэрт удаан жил хуримтлагдсан эзэнгүй хог хаягдлыг аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран цэвэрлэгээ хийлгэх ажлыг зохион байгууллаа. Уг ажлыг орон нутгийн төсвөөс санхүүжлтийг гаргаж, нийтдээ 140 тонн гаруй хог хаягдлыг цэвэрлэж, нэгдсэн хогийн цэгт буулгав.

Тухайн газрын айл өрхүүдэд тус байгууллагын холбогдох албан хаагчид орчин тойрны хогийг байнга цэвэрлэж, ил задгай хог хаяхгүй байх талаар зөвлөгөө өгч ажилласан болно.

Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, БОАЖСайдын 2022 оны 02 дугаар албан даалгаврыг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх, иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх, хог хаягдлыг багасгах хоггүй цэвэр сайхан орчныг бий болгох, иргэдийн эрүүл ая тухтай ажиллах амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор орон нутгийн төсвөөс 19 сая төгрөгийг батлуулан Өлгий сумын төвд 10 ширхэг ангилан ялгах хогийн савыг МСҮТөвд хийлгэж аймгийн төв талбай болон стадионд байршуулав.

Өсвөр насны идэвхтэн байгаль хамгаалагч, аймаг, сумын ЗДТГазартай хамтран 2022 оны 07 дугаар сарын 09,10-ны өдрүүдэд аймгийн төв талбай, стадионд зохион байгуулсан наадмын арга хэмжээнд оролцож байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад шаардлага тавьж, Хоггүй цэвэрхэн наадахыг уриалан ажиллав.

“Монгол орноо хогноос салгая” аяны хүрээнд Хар нуур, Ховд голын сав газрын захиргаа, Толбо сумын ЗДТГазрын албан хаагчидтай хамтран аялагчид ихээр ирдэг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан Толбо нуурын эрэг орчмын 5га талбайг 2 удаа цэвэрлэж нийт 10 гаруй тонн хог хаягдлыг нэгдсэн хогийн цэгт буулгаж ажиллав.

Аймгийн Засаг даргын 2022.06.03-ны өдрийн А/377 дугаартай Хоггүй Цэмцгэр Өлгий аян хүрээнд Өлгий сумын багуудын нийгмийн ажилтан, ард иргэдийн дунд 2022 оны 8-р сарын 31-нээс 2022 оны 09-р сарын 15-ны өдрийн хооронд

“ХОЛИВОЛ ХОГ, АНГИЛБАЛ БАЯЛАГ нэрт уралдааныг аймгийн ЗДТГазартай хамтран зохион байгууллаа.

Уг уралдаанд Өлгий сумын төвийн 12 багаас 7 баг оролцож нийт 23.5 портер шил, хуванцар, гялгар уут, лааз цуглуулсан. Идэвх санаачилга гаргаж их хэмжээгээр дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг ангилан ялгаж цуглуулсан эхний 3 байранд шалгарсан багуудад өргөмжлөл, гарын бэлэг болон мөнгөн шагналаар шагнав.

Уралдаанд оролцсон баг бүрээс идэвхтэй оролцсон нэг иргэнд идэвхтэн байгаль хамгаалагчийн үнэмлэх ба өргөмжлөл, гарын бэлэг, нэг байгууллагаад өргөмжлөл, гарын бэлэг олгосон.

Оролцсон багууд хамгийн ихдээ 9 портер, хамгийн бага нь 50 кг дахивар цуглуулсан байна.

Бусад холбогдох байгууллагуудад гаргаж өгөх мэдээ мэдээллийг хугацаанд гаргаж өгч ажиллав.

БАТЛАВ: БОАЖГ-ЫН ДАРГА Ш.МАРАТ